

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Осорын Индрээ	Дугаар	L021
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	
Төрсөн газар	Дундговь аймгийн Дэрэн сум	Төрсөн он	1923
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Жадамбын хийд	Сүм хийдийн дугаар	ДУДР 088
Одоогийн сүм хийд	Ламрим хийд	Сүм хийдийн дугаар	УВ 04
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 14	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Дундговь аймгийн Дэрэн сумын Жадамбын хийд

Дайчин бэйсийн хошууны хийд байсан. Жадамбын хийд Дэрэн сумнаасаа зүүн зүгт байсан. Баянбэрх гэдэг ус, Цагаанмагнай гэдэг уулын энгэрт байсан. Цагаанмагнайгаа намрын эхэн сард тахина. Хойно нь Дашбалбар гээд том хар уул бий.

Жадамбын хийд 5 дугантай, 80 хэдэн ламтай байсан. Дарь эх, Гонхон, Их дуган, Багачуул, Цогчэн дуган гэсэн дуганууд байсан.

Хийдийн нэр нь Жадамба. Тэгш, Жадамба гэдэг ах дүү хоёр лам байсан. Жадамба гэдэг нэртэй хүн байгуулсан. Тэгээд Жадамбын хийд гэж нэрлэгдсэн. Эхлээд ах дүү хоёр хамт байж байгаад дараа нь урд энгэр дээр нь Тэгш гэж үүссэн. Таарамжгүй болсон юм уу яасан юм.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 1

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хийдийн тэргүүн, цорж лам нь Чойрын багш гэж байсан. Их сайн лам байсан., гэсгүй нь Няндаг гэж байсан. Лхамжав ч гэж байсан.

Хийдийн гол шүтээн нь Лхам. Тогтмол хуралтай байсан. Төвдөө голын Их дуган, хойно нь Сахиусны гонхон, баруун урд талд Дарь эх, Хайлангийн дуган гэж байсан. Гороо гэж хийдийн дөрвөн талд дөрвөн их овоотой. Суварга ерөөсөө байгаагүй. Шавилан сууж байсан хүмүүс нь дандаа тэр хавийнхан байсан. Хүрээний 7 цоржийн нэг Хэрээ Хөхөл гэдэг газар шавилж байсан тэр цорж хааяа нэг морилж ирж ван тавьж байсан.

Цогчэн уншлагатай, янз бүрийн гүрэм уншина. Гол нь Лхам, Хангал л их тахиж Санжид Моломын бүтээл их хурдаг газар байсан юм.

Сард дүйчэнгүүдээ хурна. Цагаан сараар сороо зүүн урагшаа зална. Тэгээд Жамсрангийн буу гэж нэг эрээн буу байсан. Тэрүүгээр тусгай хүн буудна. Ерөөл хурна. Богд ламын дүйчэн өдрөөр чог хурна. Нүгнээ сахина. Хайлан 45 хийнэ. Хайланг зуны сүүл сард эхлээд намрын эхээр дуусдаг байсан. Хайланд 30-аад лам суудаг байсан. Гэлэн нь цөөн, гэцэл нь олон байсан байх. Манайд цам, Майдар байгаагүй. Ганжуураа гороогоо тойрч эргэнэ. Судраа лам нар, мөн мөргөлчид үүрээд, тэврээд эргэнэ. Лав гурван удаа тойрдог байсан байх.

Дан модон дуган байсан. Сүм дуганыг нь хятадууд барьсан гэж ярьдаг байсан.

Ойролцоо Тэгш, Бэл гэсэн хоёр хийд байсан. Тэгшээсээ 25 орчим , Бэлээсээ 30-ад км-н зайтай байсан. Энэ хоёр хийдтэйгээ харилцаа холбоотой байсан. Их хурлуудаараа ирж очдог байсан. Манайд нутагт хувилгаан гэж байгаагүй. Манай Чойрын багш бараг хувилгаан шахуу хүн байсан. Засагт л дийлдээгүй л хүн дээ. Манайх чинь Дэлгэрцогт гэдэг дээр тамгын газар байсан тэнд барьж аваачсан юм. Нэлээн сүүлд. Тэргэн дээр авч очсон. Тэд 3 хоносон. Өмхийрсөн. Тэгсэн. Энэ хүнээ аваад яв гэсэн. Гэртээ ирсэн. Миний хөөрөг хаана байна, бэрээ хаана байна гэсэн. Аваад явчихсан. Юу гэж эргүүлж өгөх вэ гэсэн. Би юмаа авна. Хүний юмыг зүгээр авдаг хүн байдаг юм уу гээд байсан. Засгийнхан аваачиж өгсөн гэсэн. Би нутаг хол байсан болохоор аваачиж өгч байхыг нь хараагүй. Хийдээс үлдсэн хөөрөг, бэрээ нь байгаа.

Манайд Багачуул жас, Их жас гэж хоёр жас байсан. Их жас нь хурал хурна. Бага жас нь хурал байхгүй. Жасын лам гэж олон байсан юм гэнэ лээ. Дандаа хээр адуутай байсан юм гэнэ лээ. Лам нар нь сүмийнхээ хойд талаар байна. Хөдөөтэй лам нар хуралдаа ирж хурчихаад мордоод явчихна.

Зоч лам нар, лүйжинч нар байсан. Гэхдээ хийд дээр байгаагүй. хөдөөгүүр л их явдаг байсан. Манай тэр хавьд хандмаа нар байгаагүй.

Тэр үеийн лам хүний амьдрал яахав. Өөр өөрсдийнхөө амьдралаар л амьдарна. Ламыгаа их хүндэтгэнэ. Лам нар цагаан идээ их иддэг байсан даа. Хийдийн ойролцоо айлууд бол байна. Худалдааны газар гэх юм бол нэг хятад наймаа байсан. Өөр олон юм байгаагүй. Хурал ном хаагдахад ном судар, бурхан тахилаас авч үлдсэн юм бараг байхгүй биз дээ. Ганц нэг овсгоотой хүмүүс магадгүй л юм.

Би хурал хаагдаад хар болоод хөдөө гарч адуу хариулж байгаад цэрэгт явсан. Сүүлдээ нэгдэлд орсон. Хотод орж ирээд 6 жил болж байна. Ирээд л энэ Ламримд хурсан.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 2